

Хамтдаа тоглоё – Харилцан суралцъя

Хэсэг I. Төсөл санаачлагчийн ерөнхий мэдээлэл

Аймаг /хот: Өвөрхангай аймаг
Сум дүүрэг: Арвайхээр сум
СЭЭБХ-ны хаяг: Эрдэмтэн зохиолч П. Хорлоогийн нэрэмжит ЕБ-ын II сургууль
СЭЭБХ-ны зохицуулагч: В. Норжин

Хэсэг IIa. Нөхцөл байдлын шинжилгээ

Давуу талыг тодорхойлох	эрэмбэ	Эрэмбэ
Бага ангийн сурагчдын унших, ярих, ойлгох чадварыг хөгжүүлэх аяныг 3 жил дараалан хэрэгжүүлж шилдэг сургалтын менежер, шилдэг сургууль, шилдэг анги, багш нар тус сургуулиас шалгарсан.	1	V
Хүүхдийг алдаагүй бичүүлж сургах арга зүй, ангитай ажиллах арга зүй гэсэн тэргүүн туршлагаа түгээн дэлгэрүүлж ажилладаг	2	IV
Бага боловсролын чанарын шинэчлэлийн төслийн хүрээнд Монгол хэлний хичээлээр дамжуулан “Монгол ёс заншлаасаа суралцъя” төсөл амжилттай хэрэгжүүлж, үүгээр дамжуулан эцэг эхчүүдийн дэмжлэг авч хамтарч ажилласан. Ингэснээр эцэг эхчүүдийн хандлага оролцоо бүтээлч байдалруу чиглэж багш эцэг эхийн хамтын ажиллагаа сайжирсан.	4	II
Багаар ажиллах нь тус сургуулийн онцлог болж байна. Мөн хичээл заах арга зүйгээ хамтран сайжруулах ажлуудыг тогтмол зохион байгуулдаг. Үүний үр дүнд аймгийн ур чадварын уралдаанд 6 удаа 1-2 дугаар байранд шалгарсан байна.	3	III
Сул талыг тодорхойлох		
Сурагчдын амжилтанд эцэг эхчүүдийн оролцоо, хувийн хандлага, ар гэрийн анхаарал халамж, эцэг эхийн мэдлэг боловсрол бага	1	V
Хичээлийн бус цагаар ажиллах анги танхимын хүрэлцээ муу	4	I
Интернет тогтмол биш, багш нарын өрөө байхгүй	5	II
Малчны хүүхэд их байдаг	2	IV
Эцэг эхчүүд сурагч хөгжих нь зөвхөн багшийн ажил гэж ойлгодог	3	III

Хэсэг IIб. Төслийн зорилго, хамрах хүрээ

Зорилго	“Мэдлэгийн богцоор дамжуулан сурагчдын эх хэлний мэдлэгийг нэмэгдүүлэн эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь”
Хамрагдах хүний тоо	1-5-р ангийн 914 сурагч, тэдний эцэг эх болон бага ангийн 28 багш

Төслөөс гарах үр дүн – Мэдлэгийн богц нь хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон өнгө үзэмж сайтай ашиглахад хялбар ойлгомжтой байна. Мэдлэгийн богцод зааварчилгаатай CD 1ш, гарын авлагатай зааварчилгаа 1ш, дүрмийн гарын авлага хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргатай CD 1ш, танин мэдэхүйн гарын авлага 1ш, Хосоороо тоглоом 1ш, картан тоглоом 1ш тус тус байна.

Заавар: 1

А. Мэдлэгийн богцтой хэрхэн ажиллахаа анхааралтай унших эсвэл CD-ыг үзэх
 Б. Дүрмийн гарын авлагаас шинэ дүрэмтэй танилцана \1-5 ангийн гарын авлага өөр өөр байна\
В. Танин

мэдэхүйн гарын авлагатай танилцана.\ 1-5 ангийн гарын өөр өөр байна\ мөн CD гээр үзэх Г.Хосоороо

тоглоом тоглохдоо: Монгол хэлний зөв бичих болон унших дүрэм бүхий картуудыг хамгийн ихдээ 3 шулуун 2 өнцөг үүсгэх замаар авч тоглоно.Зургаар үзүүлэн тайлбар байна. Д.Картан

тоглоом тоглохдоо:Монгол хэлний зөв бичих болон унших дүрэм бүхий картуудыг хэзэр тоглож байгаа мэт ашиглан тоглоно. Жишээ нь зургаар харуулав.

2.Мэдлэгийн богцоо номын өргөөнд бүлгийн тоогоор 32 ширхэг байрлуулна.Хуваарийн дагуу ангийн эцэг эх сургууль дээр хамтран ажиллах Малчны хотхоноор 25 ширхэг малчин эцэг эхчүүдэд сургалт хийх явцдаа ахлагч сонгон хот айлдаа таниулан аялуулан Сумын эцэг эхчүүдэд 20 бүлэг тус бүрд ангид 16 ширхэг мэдлэгийн богц аялуулна.

3.Мэдлэгийн богцод орох хэрэглэгдэхүүний агуулгыг зохиож хийхэд СЭЭБХ-ны удирдах зөвлөлийн гишүүд бүгд оролцоно.\Бага ангийн багш нараас зөвөлгөө авна./

4.I анги: Эцэг эх сурагчид картын зургийг нэрлэж, авиаг үгийн эхэнд, дунд, төгсгөлд байгааг хэлж сурахаас гадна унших, ярих,бичих, хэлзүйн чадварууд эзэмшинэ.

II анги: Амьтны үр төлийг нэрлэн, эм үгийг ялгаж -ын, -ийн, -ы, -ий нөхцлийг зөв залгаж сурах, унших, ярих,бичих, хэлзүйг чадварууд ой тогтоолтын холимог ойн чадваруудыг давхар эзэмшинэ

III анги: Гэр хэрэгсэлийг нэрлэж, ялгах эгшигтэй үгсийг нэрлэн зөв бичиж сурна. унших, ярих,бичих, хэлзүйг чадварууд ой тогтоолтын холимог ойн чадвар, бүтээлч сэтгэлгээ давхар хөгжинэ.


IV анги: Хэн?, юу? асуултад хариулагдах үгсийг нэрлэж, урт эгшгээр эхэлсэн залгавруудыг зөв залгаж сурна. унших, ярих,бичих, хэлзүйг чадварууд ой тогтоолтын холимог ойн чадвар,логик бүтээлч сэтгэлгээ давхар хөгжинэ.

V анги: Зургийг нэрлэн, “л” дагаврыг зөв залган бичиж сурна. унших, ярих,бичих, хэлзүйг чадварууд ой тогтоолтын харах,сонсох,хөдөлгөөний, холимог ойн чадвар,логик,бүтээлч сэтгэлгээ давхар хөгжинэ.

5.Эцэг эх хүүхдээ авах гэж хүлээж байхдаа завсарлагааны цагаар чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, монгол хэлний зөв бичих унших дүрэм бүхий мэдлэгийн богцод байгаа хосоороо тоглоом,картан тоглоомыг тоглох орчин бий болгоход зориулсан зориулалтын самбар байна.

5.Мэдлэгийн богцоо баяжуулах нь сэдэвт эцэг эх, сурагчдын хамтарсан бүтээлийн уралдаан нь сургуулийн 2,3 давхарт хосоороо тоглоом,картан тоглоом байрлуулах самбарт анги бүрийн эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамтран бүтээл хийснээр бие биеэсээ суралцах эцэг эхээс эцэг эх, эцэг эх хүүхэд хамтран мэдлэг бүтээх орчин бий болно.Хамгийн их оролцоотой ангийн эцэг эх,зэргэд бүлгийн эцэг эхчүүдийг татан оролцуулах бүтээлч сэтгэлгээг нь давхар хөгжүүлэх мэдлэгийн богцоотойгоо ажиллах бодит чадвар болон тогтох юм.Цаашид бага ангийн 914 сурагч тэдгээрийн эцэг эхчүүд мэдлэгийн богцоо өөр олон төрлийн хичээл дээр ашиглаж чаддаг болно.Аль ч хичээлд хэрэглэх дунд,ахлах ангид хэрэгжүүлэх боломжтой.

Хэсэг IIIa. Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт



Хэсэг IIIБ. Төслийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

д/д	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа	Хүрэх үр дүн
1	I-V ангийн сурагчдын “Монгол хэл”-ний хичээлийн чадварыг ахиулах мэдлэгийн богцын агуулга, хэрэглэгдэхүүнийг боловсруулах /анги тус бүрээр ялгаатай байх/	СЭЭБХ	2019.9-р сар	I-V ангийн багш, эцэг эхчүүд, сурагчид хамтран ажиллана.
2	Мэдлэгийн богцод байх хэрэглэгдэхүүн хийх /анги тус бүрээр ялгаатай байх/	СЭЭБХ	2019.9-р сар	Мэдлэгийн богц дахь хэрэглэгдэхүүн бэлэн болно
3	Мэдлэгийн богцтой ажиллах арга зүйн сургалтын агуулгыг боловсруулах дарааллыг гаргаж бэлтгэх	СЭЭБХ	2019.9-р сар	Эцэг эх, сурагчид мэдлэгийн богцтой ажиллахад хялбар болно.
4	Төслийн нээлт	СЭЭБХ	2019.9-р сарын 20	Сургуулийн удирдлага, багш нар, эцэг эхчүүд, иргэд, малчин эцэг эхчүүд нээлтийн арга хэмжээнд оролцож төслийн үйл ажиллагаатай танилцана.
5	АУБ нар, эцэг эхчүүдэд мэдлэгийн богцтой ажиллах арга зүйд сургах	СЭЭБХ	2019.10-11-р сар	Мэдлэгийн богцтой ажиллах арга зүйг эзэмшинэ. Нийт 32 бүлгээс гурав гурван эцэг эхэд мэдлэгийн богцтой ажиллах арга зүйд сургах эцэг эх нь цааш нь 960 эцэг эхчүүдэд түгээн дэлгэрүүлэн сургана.
6	Мэдлэгийн богцтой ажиллах хуваарийг бүлэг тус бүрээр гаргах -Дотоод аудитын багийн гишүүд ажиллана.	СЭЭБХ	2019.10-р сар 11 сард	Үдээс өмнө, үдээс хойш зэргэд бүлгийн эцэг эх, сурагчид хамтран ажиллах боломж бүрдэнэ.
7	Анги тус бүрээр чадварын дагуу сэдэв бэлтгэн шалгалт авч гарааны үнэлгээгээ гарна.	СЭЭБХ АУБ нар	2019.12-р сар	Мэдлэгийн богцод тусгасан үгсийг таних,зөв бичих чадвараар гарааны үнэлгээг тогтооно.
8	Номын өргөөнд 32 богц байрлуулж хуваарийн дагуу эцэг эх хүүхэдтэйгээ хамтран ажиллах Нийт 1-5 ангийн зэргэд 32 бүлгийн тоогоор нэг ангид нэг гэж тооцож байлгана.	Номын санч СЭЭБХ	2019.12-р сараас 5-р сар хүртэл	Монгол хэлний зөв бичгийн дүрмийн мэдлэг бичих,унших,хэлзүйн сайжирна.
9	Мэдлэгийн богцоо сурталчилах - Олон нийтийн сүлжээ - Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл	СЭЭБХ	2020.9.20-5сар	Үйл ажиллагаа бүрийг баримтжуулан, бусдад түгээн дэлгэрүүлнэ. мэдээлэл маягаар хүргүүлнэ.

10	<p>“Мэдлэгийн богц Малчны хотонд”</p> <p>- Өөрийн сургуулийн харьяа хүүхдүүдийн судалгаа гарган багийн хурал, сумын хурал хэзээ болохыг мэдэж тухайн газарт очиж сургалт мэдээлэл өгч ажиллах багийн ахлагч сонгох тухайн ахлагч өөрийн хот айлдаа түгээн дэлгэрүүлж ашиглах</p>	СЭЭБХ	1-р улирлын амралт	Малчин эцэг эх мэдлэгийн богцтой танилцаж, хүүхэдтэйгээ хамтран ажиллан харилцан суралцана. Бүх сум багуудаар явах боломжгүй учраас хамгийн их манай сургуулийн суралцагчтай Өлзийт,Зүүнбаян-Улаан,Тарагт сумын нийт 75 эцэг эх цааш нь бусад малчин эхчүүдэд түгээн дэлгэрүүлэн хот айлуудад ашигладаг болно
11	<p>“Малчны хотноос мэдлэгийн богцод”</p> <p>Мэдлэгийн богцоо эцэг эхийн төлөөлөл ахлагч гарсан үр дүнгээ танилцуулан мэдлэгийн богцоо СЭЭБХ нд хүлээлгэж өгнө. Малчин эцэг эхчүүдийн төлөөлөл сургуульдаа ирж хүүхэд эцэг эх багшдаа хэрэгжүүлсэн туршлагаа хуваалцана.</p>	Малчин эцэг эх	IY улирлын эхний долоо хоногт	Малчин эцэг эх мэдлэгийн богцоо хүүхэдтэйгээ хамтарч тоглодог болсноор монгол хэлний зөв бичих дүрэм дээшилж эцэг эх багшийн гурвалсан холбоо сайжирч хүүхдийн сурлагын чанарт амжилт гарна.
12	<p>Эцэг эх хүүхдээ авах гэж хүлээж байхдаа завсарлагааны цагаар чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, монгол хэлний зөв бичих унших дүрэм бүхий мэдлэгийн богцод байгаа хосоороо тоглоом,картан тоглоомыг тоглох орчны самбар хийх</p>	Эцэг эх, сурагч, АУБ нар СЭЭБХ	Сард 1 удаа	1-5-р анги сэдвүүдээ сар бүр шинэчлэн самбарт байрлуулан хүүхэд, эцэг эх, багш хөгжих, оролцох таатай нөхцөл бүрдэнэ.
13	<p>“Мэдлэгийн богцоо баяжуулах нь” сэдэвт эцэг эх сурагчдын хамтарсан бүтээлийн уралдаан</p>	Эцэг эх, сурагч, АУБ нар СЭЭБХ	2020.04.1-5.1	Бүтээлийн 2,3 давхарын самбарт байрлуулна Эцэг эхийн оролцоо нэмэгдэж, хүүхдийн өөртөө итгэх итгэл нэмэгдэнэ. Анги тус бүрээр бүтээлийг гаргаж эцэг эх сурагч бие биенээсээ суралцах хөгжих, бүтээх сонирхлыг нэмэгдүүлнэ.
14	Сурагчдын ахицыг үнэлэх	АУБ нар СЭЭБХ	2020.4-р сарын эхний 7 хоног	Мэдлэгийн богцод тусгасан үгсийг таних,зөв бичих чадвараар гарааны үнэлгээнд хэрхэн ахиц өөрчлөлт гарсныг үнэлнэ.
15	Сургуулийн авьяасын тайлан дээр үзүүлэх тоглолт хийж\ Монгол хэлний зөв бичих унших дүрэм бүхий хосоороо тоглоом, картан тоглоомыг ашиглан эцэг	АУБ нар СЭЭБХ	2020.4-р сарын сүүлийн 7 хоногт	Би хөгжинө – Бид хөгжинө – Бүгдээрээ хөгжинө

эхчүүд сурагчид тоглож үзүүлнэ. 1-5 ангийн эцэг эх сурагчид өөрсдийн сурч мэдсэн зүйлээ бусдад түгээн дэлгэрүүлж тайлагнана.			
--	--	--	--

Хэсэг IV. Зардлын задаргаа

д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ, төг	Нийт үнэ, төг	Тус бүрд нь хүрэх үр дүн (Хүүхдэд ямар бодит үр дүн авчрах, ямар чадварыг эзэмшүүлэх)
Бүлэг 1: Сургалтын хэрэглэгдэхүүн, материал						
1	Мэдлэгийн богц	ш	100	2500	250,000	Гарын авлага хийх цүнх
2	Зөв бичих дүрмийн тайлбар толь гарын авлага	ш	100	1500	150,000	Анги бүрт тохирсон дүрмүүдийг түүж тайлбарласан эх бэлтгэх
3	Зөвлөмж	ш	100	1000	100,000	Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, гэрийн даалгаврыг хэрхэн үр дүнтэй хийх, нас сэтгэхүйн онцлогийг агуулсан мэдээлэл байна
4	Картан тоглоом хийх сав	ш	100	2000	200000	Хэзрийг нэг цаасан дээр 6 байхаар тооцож эхээ бэлтгэн, фото цаасан дээр гаргаж ламинатордана.
5	“Хосоороо” тоглоом хийх сав	ш	100	2000	200000	нэг цаасан дээр 8 байхаар тооцож эхээ бэлтгэн, фото цаасан дээр гаргаж ламинатордана
7	Ламинатор А4цаас	ш	4	20000	80,000	Мэдлэгийн богц болон гарын авлага, ном, үзүүлэн эцэг эх сурагчид нээлттэй тоглоомоор тоглох хэрэглэгдэхүүн бэлтгэхэд хэрэглэнэ.
8	Ламинатор цаас А3	ш	7	25000	175,000	
9	А3 цаас	ш	7	20000	140,000	
10	А4 бичгийн цаас	ш	30	11000	330,000	
11	Фото цаас /хуулдаг, хуулдаггүй	ш	8 2	30000 15000	240,000 30,000	
12	Ламинаторын машин		1	70000	70,000	
13	Соронз		30	3500	105,000	
14	Тоглоомын самбар		2	200,000	400,000	Мэдлэгийн богцод байгаа хосоороо тоглоом, картан тоглоомоор бүлэг бүрийн эцэг эхчүүдийн санаачлан хийсэн Монгол хэлний унших бичих дүрмээр хийсэн бүтээлээ байрлуулах Бага сургуульд 2ш багш

						эцэг эх сурагчид хэдийд ч тоглож болох бүтээлч цагийг үр бүтээлтэй өнгөрөөх орчин бүрдэх
15	Акустик хавтан		1ш	60000	60000	Мэдлэгийн богцод байгаа тоглоомоо самбарт байрлуулахад дунд нь хавчуулан хийх наах материал хүүхдэд аюулгүй
16	Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга VCD Зааварчилгаатай CD		100	5000	500000	Малчин эцэг эхчүүдэд очиж сургалт хийх, өгөх болон номын өргөөнд байрлуулж үзүүлэх
17	Өнгөт принтер		1	495000	495,000	EPSON 360 гурван үйлдэлтэй
18	Өнгөт притерийн хор	4ширхэг 5удаа	3	40000	120,000	Гарын авлага ном сурах бичгийн хувилахад хэрэглэнэ.
19	Хар принтерийн бул		2	75000	150,000	Хэвлэж хувилах
Бүлэг 3: Сургалт						
	Мэдлэгийн богц аялуулах малчин эцэг эхчүүдэд сургалт хийх		Зөдөр	120,000	360,000	Малчин эцэг эхчүүд дээр очиж мэдлэгийн богцтой ажиллах арга зүйг ойлгуулан, сурагчидтай хамтран богцтой ажиллах чадварт суулгана. Бусад малчин эцэг эхчүүдэд түгээн дэлгэрүүлэх \хот айлуудад \ Хот айлын ахлагч мэдлэгийн богцийг бусад малчин эцэг эхчүүдэд ашиглах, хамтран ажиллах, мэдлэгийг өгч хэрэгжүүлсэн туршлагаа сургууль эцэг эхчүүд багш нар сурагчидтай ирж хуваалцах Аймгийн төвөөс Өлзийт сум 40-75км \ Зүүнбаян-Улаан сум 30-45 км Тарагт сумын малчин эцэг эх 20-30 км
			60литр	2000	120000	
	Эцэг эхэд арга зүйн сургалт хийх		5 удаа	1-р анги 7 бүлэг 21 2-р анги 6 бүлэг 18	180000	Зэрэгт анги бүрийн эцэг эхийн төлөөлөлд 5 удаа ээж аавд сургалт хийнэ. Нийт 90 эцэг эхэд 1 удаа 2000 төгрөгийн үйл ажиллагааны зардал /Сургалтын цайны

				3-р анги 6 бүлэг 18 4-р анги 6 бүлэг 18 5-р анги 5 бүлэг 15		материал, тараах материал хэвлэх хувилах/ Анги бүрийн эцэг эхчүүд ангиддаа очиж түгээн дэлгэрүүлэн мэдлэгийн богцоо баяжуулан хамтран ашиглах.
	Эцэг эхчүүдийг идэвхжүүлэх мэдлэгийн богцоор баяжуулсан бүтээлийн уралдаан		1 удаа	25000х5	125,000	Зэргэд бүлэг тус бүрээс нэг нэг анги шалгаруулна.Эцэг эх багшийн хамтын ажиллагаа сайжирна. Хүүхдийн ахиц хөгжлийг тухай бүрт нь үнэлэх боломж гарна. Үйл ажиллагаандаа тусгах, юу сурсан бэ бусаддаа түгээх амжилт гаргасан анги хамт олныг шагнаж урамшуулна.Эцэг эхийн оролцоо нэмэгдэнэ.Ангийн бүгд эцэг эх болгон оролцоно. \батламж өргөмжлөл\
Бүлэг 4: Үйл ажиллагааны зардал						
	Харилцаа холбоо, гэр интернэтийн зардал		9 хүн	9х15000	135000	Харилцаа холбоо, банкны шимтгэл,
	Шатахууны зардал		9 хүн	9х20000	180000	Удирдах зөвлөлийн явцын үйл ажиллагаанд оролцох унааны зардал
	Уулзалтын зардал		20	20000	400000	Бэлтгэл үйл ажиллагаа,төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх,тайлан мэдээ гаргах
	Төслийн нээлт, хаалтын урилга		40	1000	40,000	Шийдвэр гаргах түвшний хүмүүс, үнэмлэхтэй гишүүдэд урилга өгөх
	Банкны шимтгэл					10%
	Бүгд				5,333,7	

Төслийн тогтвортой байдал

2018 оны хичээлийн жилд “Хамтдаа тоглоё – Харилцан суралцъя” төслийг хэрэгжүүлснээр сурагчдыг эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлж тулгардаг бэрхшээлийг хамтдаа даван туулах, багш эцэг эх сурагчийн холбоо улам батжиж сурагчийн сурлагын чанарт амжилт гаргаад зогсохгүй өөртөө итгэх итгэл, гэр бүлийн эерэг уур амьсгал бүрэлдэн тогтох нөхцөл байдал бүрэлдэн бий болно. Энэхүү ангид олсон мэдлэгээ эцэг эх найз нөхөдтэйгээ хамтдаа зэрэг хөгжих, суралцагчдын сурлагын чанарт ахиц гарах, багшийн ажлын ачаалал мөн давхар олон хүмүүжлийн асуудлыг нэг дор шийдэх боломж бүрэлдэж байна. Цаашид үргэлжлүүлэн цөм хөтөлбөртэйгээ уялдуулан хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм.

- 1-5-р ангид бага боловсролын цөм хөтөлбөр хэрэгжүүлж байгаатай холбогдуулан “Хамтдаа тоглоё – Харилцан суралцъя” төслөө сургалтын үйл ажиллагаанд тусгаж сурагчдын сурлагын чанар ахиулах, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлнэ.

- “Хамтдаа тоглоё – Харилцан суралцъя” хөтөлбөрийг сургалтыг дэмжих хичээлийн цагуудтай уялдуулан “Номын өргөө”-тэй хамтран “Монгол хэл” “Математик” “Хүн байгаль” Хүн-Нийгэм хичээлээр мэдлэгийн богцоо баяжуулах хэтийн зорилготой байна.
- Хүүхдийг хөгжүүлэх”-ын үйл ажиллагааг тогтворжуулан, сургуулийн нэгдсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж хэвших, сургалтанд хэрэглэх хэрэглэгдэхүүнүүдийг баяжуулна.
- Нийт 30 бүлгийн 914 хүүхдийн сурлагын чанарт ахиц гараад зогсохгүй, цаашид дунд, ахлах ангиудад хэрэгжүүлэх боломжтой.

Арвайхээр сум ЕБ-ын 2 дугаар сургуулийн эцэг эх багшийн холбоо зохицуулагч В.Норжин

Төслийн саналыг дэмжсэн гишүүдийн гарын үсэг, нэр :

СЭЭБХ-ны Зохицуулагч: Нэр: В.Норжин Гарын үсэг / *В.Норжин* /

Төслийг боловсруулсан:	Эцэг эх <i>С.Дашзэвэг</i> /С.Дашзэвэг/	Огноо: <i>д.д.д.</i> он. <i>д.</i> сарын <i>д.</i> өдөр
	Эцэг эх <i>Г.Болбаатар</i> /Г.Болбаатар/	
	Эцэг эх <i>М.Мягмарсүрэн</i> /М.Мягмарсүрэн/	
	Эцэг эх <i>Я.Чанцалдулам</i> /Я.Чанцалдулам/	
	Багш <i>Цэнд</i> /Г.Цэнд/	
	Багш <i>Н.Одончимэг</i> /Н.Одончимэг/	
	Багш <i>Тунгалагмаа</i> /Г.Тунгалагмаа/	
Багш <i>Д.Цэрэнсодном</i> /Д.Цэрэнсодном/		

